

## «ХЯТАДЫН ТҮҮХ»

(Ерөнхий боловсролын дунд сургуулийн сурах бичиг, Бээжин, 1981 он. 4 дэвтэр)

Уршигт «соёлын хувьсгалын» дараа 1977 оноос эхлэн БНХАУ-д түүхийн холбогдолтой ном зохиолуудыг олноор хэвлэн гаргах болов. Хятадын маоист түүхчид марксист түүх судлалаас бүрмөсөн ухарч дэлхий дахины түүх, хөрш зэргэлдээх улс орны түүх, түүний дотор хятадын түүхийг өөрсдийн жанжлах эрх ашиг, бодлогодоо тохируулан гуйвуулсаар байна.

1981 онд Бээжинд хэвлэгдсэн «Хятадын түүх» (Дунд сургуулийн сурах бичиг) нь дөрвөн дэвтрээс бүрдсэн бөгөөд балар эртний үеэс 1977 он хүртэлх хугацааг хамарчээ. Уг ном энгийн, уншихад амархан хэллэгээр бичигдсэн нь зөвхөн дунд сургуулийн сурагчид төдийгүй нийт уншигчдад тусгай зориулгатай харш ойлголт өгөхөд чиглэгдсэн нь тодорхой.

«Хятадын түүх» номын нэгдүгээр дэвтэр нь хятадын хүй нэгдлийн үеэс эхлэн м. э. 589 он хүртэлх үеийг хамарчээ.

Уг хэсэгт эртний хятадын эзэнт улсуудтай зэргэлдээ оршиж байсан Хүннү, Сяньби зэрэг хойт зүгийн нүүдэлчин улс аймгуудыг хятадын нутаг дэвсгэрт багтаж байсан мэтээр дүрслэхийг оролдсон байна (Номын 77-р тал). Тэгээд Зүүн Хан улсын үед хятадын хилийн дотор хятад, хүннү, сяньби, тоба, баруун хязгаарын буюу өнөөгийн уйгур, казах зэрэг ард түмний өвөг дээдэс олон үндэстэн амьдарч, тэдгээр үндэстэн ард түмнүүдийн нөхөрсөг холбоо байнга бэхжиж ирлээ гэсэн ташаа дүгнэлт хийжээ. Умард хүннү нараас хятадын зүүн Хан улс руу дайтаж, түүнд учруулж байсан хор хохирол гэгчийг тоочин бичсэн байтлаа умард хүннүгийн эсрэг хятад хаадын хийсэн түрэмгий аян дайны улмаас хүннүд учирсан аюул хохирлыг дурдсангүй түүхэн үнэнийг гуйвуулжээ. Номын 97-р талд Хүннү, Сянь-би, Цзе, Ди зэрэг үндэстнүүд эрт дээр үеэс эхлэн «манай улсын хойд ба баруун өргөн уудам газар нутагт нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдардаг байв. Зүүн Хан улсын үеэс эхлэн тэд дотор газар руу шилжиж, хан үндэстэнтэй холбоогоо улам бэхжүүлсэн юм» гэжээ. Ийнхүү түүхийн үүднээс биеэ даасан, өвөрмөц онцлог бүхий үндэстнүүдийг хятад үндэстний салаа мөчир мэт болгож, Төв Азийн нүүдэлчид ба Хятадын хаад ноёдын хоорондын тэмцлийг аль болохоор нэг улсын, тухайлбал хятадын доторхи ангийн тэмцэл байсан гэж нотлохыг оролджээ.

Номын хоёрдугаар дэвтэрт Суй, Тан (581-907он) улсын үеэс Чин улсын үеийг хамарчээ.

Тан улсын үед нүүдлийн мал аж ахуй эр-

хэлдэг байсан кидан нар хүчирхэгжиж, улмаар Хятадын хойд мужуудыг эзлэн Ляо улсыг байгуулсан юм. Гэтэл тус номонд «Тан улсын засгийн газраас баруун хойд зүгийн районы улс төр, эдийн засаг, цэргийн хүрээнд явуулж байсан арга хэмжээнүүд хойд ба баруун хойд зүгийн район (Ляо улс) нь хятадын газар нутаг болохыг түүхэнд бүрэн баталсан юм» гэжээ. (2-р дэвтэр, 17-р тал) Түүнчилэн зүрчид нар Умард Хятадыг байлдан дагуулж Алтан (Цзинь) улсыг (1115-1125) байгуулан, хятадын хүн ардыг нь зовоож, улмаар Өмнөд Хятадын Сүн улсыг маш хүнд байдалд оруулж байсан юм. Гэтэл сурах бичигт Алтан улс хятадыг түрэмгийлж байсныг аль болохоор бүрхэгдүүлж, харин хятадын нутаг дэвсгэр дээр «үндэстний цөөнхийн ард түмний төр байгуулагдаж байв» гэжээ.

XIII зууны үед Төв Азид Монголын феодалын улс байгуулагдсаны дараа Чингэс, Хубилай зэрэг хаад ноёд түрэмгийлэл явуулж, хятадыг эзлэн монголын Юан улсыг байгуулсан юм. Монголын байлдан дагуулагчид Хятадад ноёрхлоо тогтоогоод их хэмжээний татвар, түрээс авч хун ардыг боолчилж, тухайн үеийн хятадын эдийн засаг, соёл, нийгмийн хөгжилд ихээхэн саад учруулсан юм. Гэтэл өнөөгийн хятадын түүхчид Монголын феодалын байлдан дагуулал, Юан улсын ноёрхлыг магтан дэвэргэж байгаа нь санамсаргүй хэрэг биш юм. Хоёрдугаар дэвтрийн 64-р талд «Монгол үндэстэн бол манай улсын доторхи эртний үндэстний цөөнх юм», 66-р талд «Юан улсын нэгдэл манай нэгдмэл олон үндэстэн бүхий улсын хөгжлийг урагш ахиулж, үндэстнүүдийг нийлүүлэх явдлыг хурдасгасан юм» гэж монгол зэрэг биеэ даасан улс үндэстнүүдийн түүхийг ноцтой гажуудуулан гуйвуулж байна.

Манж Чин улсын үед хятадууд 260 гаруй жил харийн ноёрхолд нухлуулж байсан билээ. Гэтэл Чин улсын үед хятадын газар нутаг өргөжиж байсан хэмээн манжийн эзлэн түрэмгийлэгчдээс явуулж байсан бодлогыг маогийнхан мөн л зүй бусаар магтан бичиж байна.

«Сибирь бол Юан улсын нутаг дэвсгэрт багтаж байсан» (2-р дэвтэр 67-р тал), «Хаант Орос бол Европын улс», «16-р зууны сүүлчээр хаант Орос Уралын нурууг даван зүүн зүг рүү чиглэж Сибирийн өргөн уудам нутгийг эзлэн авсан юм». (112-р тал) гэх зэргээр өнөөгийн хятадын удирдагчдаас Зөвлөлтийн Сибирь нутаг

руу өнгөлзөх бодлогыг түүхэн ул үндэстэй  
болгохыг

оролдсон байна. Манж нарын ноёрхолд зөвхөн хятад биш мөн монгол, уйгур, хасаг зэрэг үндэстнүүд орж байсан явдлыг ашиглан «Манж Чин улсын үед үндэстнүүдийн эв нэгдэл улам бэхжиж ирлээ» хэмээх хуурамч дүгнэлт хийхийг оролдож байна. (2-р дэвтрийн 119-127-р талд) «Манж улс нэгдмэл олон үндэстний улсыг бэхжүүлэхийн төлөө тэмцсэн нь» гэдэг гарчгийн дор манжийн түрэмгийллийн эсрэг улс орныхоо тусгаар тогтнолын төлөө тэмцэж байсан монгол, уйгур, төвд, хотон зэрэг үндэстнүүдийн үндэсний эрх чөлөөний тэмцлийг манжийн засгийн газраас хэрцгийлэн дарж байсныг сайшаан бичсэн байна. Жишээ нь 2-р дэвтрийн 119-р талд «Чин улс Зүүнгарын язгууртан нарын будлианыг төвшитгөсөн нь» гэдэг гарчгийн дор Баруун Монголын Зүүн гарын хаант улсын ард түмэн, жич Галдан бошгит, Амарсанаа нарын зүгээс манжийн эсрэг баатарлаг тэмцэж байсныг Хятад «эх орноо хагалан бутаргахын төлөө» (2-р дэвтэр 120-р талд) «үймээн гаргачид» (2-р дэвтэр 121-р талд; хэмээн гаж буруу дүрсэлжээ. Ийнхүү тэд Монгол эх орныхоо тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө тэмцэгч баатруудыг «хятадын түүхэнд үймээн, самуун дэгдээгчид, хагалан бутаргагчид, эх орноосоо урвагчид» хэмээн үзэж байгаа нь марксизм-ленинизм, түүхийн шинжлэх ухаанд үнэхээр их харшлах санаа юм.

Хятадад ноёрхлоо тогтоож байсан Монгол, манжийн ноёрхлыг харийн түрэмгийлэгчдийн ноёрхол биш, харин нэг улсын доторхи үндэстнүүдийн ноёрхол гэдэг үзлээр бичиж харийн түрэмгийлэгчдийн эсрэг хятадын ард гүмний үндэсний эрх чөлөөний тэмцлийг ангийн тэмцэл байсан мэт ойлгуулахыг оролджээ. Ямарваа нэгэн үндэстэн харийн дарлал, колоничлолд орвол түүний нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилд их саад учруулдгийг түүх нэг биш удаа харуулсан билээ. Хятад түүхчид Юан, Чин улсын үед хятадын нийгэм хүчирхэгжин хөгжиж ирлээ хэмээн үзэж, харин ард түмэн, улс эх орондоо учирч байсан хор хохирлыг нуун дарагдуулахыг хичээж байна. Энэ нь өнөөгийн хятадын эрх баригч бүлгийнхнээс хөрш зэргэлдээ орших улсын нутаг руу түрэмгийлэх бодлогоо «түүхэн ул үндэстэй» болгохыг оролдож байгаатай холбоотой билээ.

Сурах бичигт хаант Орос улс хятадын газар нутгийг эзэлсэн юм гэдэг ойлголт өгөхийг махран оролджээ. Жишээ болгон өгүүлэхэд гуравдугаар дэвтрийн 133-р талд хаант Орос удаан хугацааны турш «хятадын гадаад Монголыг» өөрийн харьяат гэж үзэн, цөөн тооны монгол язгууртан ван гүн нарыг өдөөн хатгаж, өөрийн талд элсүүлэн,

хятадыг хагалан бутаргаж, Цагаан Хэрэм хүртэлх өргөн уудам нутаг дэвсгэрийг эзлэхийг улайран оролдсон юм гэх буюу «1911 оны долдугаар сард Хаант Орос Өргөө (Их Хүрээн)-д Богд Жибзундамбыг хаант Оросыг түш хэмээн толгойг нь эргүүлж гадаад Монголыг Хягадаас салган «тусгаар тогтноулахаар төлөвлөсөн юм» гэх зэргээр туйлын харш үзэл дэлгэсэн байна. Энэ бүхэн нь түүхэн үнэн байдлыг их хан үндэстний дээрэнгүй маоист байр сууринаас мушгин гуйвуулж байгааг нь бүр ч тодорхой болгож байна.

«Хятадын түүх» хэмээх энэхүү номонд биеэ даасан, тусгаар тогтносон монгол улс, түүний түүхэн бодит байдлыг илтэд үгүйсгэхийг оролдсон байна. Гуравдугаар дэвтрийн 134-р талд «1913 онд хаант Орос Гадаад Монголд «автономит эрх» тогтоов. Энэ нь үнэн хэрэгтээ хаант Орос Гадаад Монголыг хяналтандаа авсан юм» гэжээ. Ийнхүү Ар Монгол хятадын жанжлалд оролгүй үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан түүхэн баримтыг маогийнхан хорсолтойгоор занаж байгаа хэрэг юм.

Номын дөрөвдүгээр дэвтэрт Хятадын шинэхэн үеийн түүхийг 1957 он хүртэл хамруулан бичжээ.

ХКН үүсэхээс эхлэн ХКН-ын түүхийн бүхий л явцад Мао Зедуны гүйцэтгэсэн үүрэг ролийг хэт төвийлгөн (4-р дэвтэр 9-р тал), түүний бичсэн өгүүлэл, заалтуудыг хятадын сүүлийн үеийн түүхийн гол баримт мэт болгон зөвтгөхийг оролджээ. «Хятадын түүх» номыг 1957 он буюу хятадын социалист бүтээн байгуулалтын үеийн ололт амжилтын үеэр төгсгөл болгожээ. Гэхдээ тэр үед ЗХУ-аас хятадын ард түмэнд үзүүлж байсан интернационалч тусламжийн тухай дурдахыг ч хүссэнгүй, хятадын ард түмнээс ЗХУ-ын дэмжлэг тусламжинд гүн талархаж байсан түүхэн баримтуудыг зориуд хассан байна.

«Хятадын түүх» хэмээх энэхүү 4 дэвтэр ном нь хятадын эрх баригчдын их гүрний жанжлах маоист үзлээр залуу үеийг мунхруулж эзлэн түрэмгийлэх санаархал номлосон хэтийн хорон санаат харгис зорилго агуулжээ гэхэд бүрэн болох байна. Ингэж залуу үе, нийт хөдөлмөрчдийг, их гүрний жанжлах дээрэнгүй үзлээр хүмүүжүүлэхийг оролдох бух хэлбэрийг бид хүн төрөлхтний өмнө үйлдэж байгаа хамгийн бузар булай гэмт хэрэг гэж үзнэ.

Марксист түүхчид, дэвшилт эрдэмтэн, сэхээтэн нар түүхийн шинжлэх ухааны эрдмийн бүтээл, сурталчилгааны зохиол, ялангуяа хүүхэд багачуудад залуу үеийг аль болохоор үнэн зөв мэдлэг олгож, интернационалч хүнлэг

иргэншлийн ёс, улс түмний найрамдал, хамтын  
ажиллагаа, ойртон нягтрах үзэл

санаагаар хүмүүжүүлэхийг зорьдог, тийм үзэл санааны үндэстэй сурах бичиг, гарын авлагыг л

сурагчиддаа бүтээн өгөхийг зорьдог билээ.  
Н. Алтанцэцэг

#### **А ХОДЖАЕВ. ЦИНСКАЯ ИМПЕРИЯ, ДЖУНГАРИЯ И ВОСТОЧНЫЙ ТУРКЕСТАН. М., 1979. 128 с.**

Хятад бус үндэстэн, түүний дотор Монгол, Төвд, Уйгур зэрэг хэзээнээс нааш биеэ даасан хэл, соёлтой, өөрийн гэсэн нутаг дэвсгэртэй, түүн дээрээ төр улсаа байгуулсаар ирсэн эртний соёлт үндэстнүүдийн түүхийг эдүгээ хятадын түүхчид их хан үндэстний дээрэнгүй үзлийн үүднээс зориуд гуйвуулж буй нь дэлхий дахинд илэрхий байна. Чухам ийм үед Зүүнгар, Дорнод Туркестаны түүх нийт дэвшилт түүхчид, Дорно дахиныг судлагч эрдэмтдийн анхаарлыг татаж буй нь санамсаргүй хэрэг биш юм.

Дорно дахины судлалын энэ салбарт юуны өмнө Орос, Зөвлөлтийн түүхчид цаглашгүй их хувь нэмэр оруулсан бөгөөд оруулсаар байна. Ялангуяа Хятадын түүх бичлэгт маоизмын хор нөлөөгөөр Чин улсын байлдан дагуулалтыг зөвтгөж Зүүнгар, Дорнод Туркестаныг угаасаа Хятадад харьяалагдаж байсан гэх буюу тийм учраас XIX зууны хоёр дугаар хагаст Чин улсаас Синьзянд явуулсан хүйс тэмтрэх, залхаан цээрлүүлэх үйл ажиллагааг цагаатгах болсон тавиад оноос хойш, хятадын түүхчдийн энэхүү түүх завхруулалтыг илчлэн няцаахад зөвлөлтийн нэрт эрдэмтэд, хятад судлаачид бүтээлээ зориулсаар байгаа бөгөөд ийм зохиолын нэг бол А.Ходжаевын «Цинская империя, Джунгария и Восточный Туркестан» юм.

Энэхүү ганц сэдэвт зохиол утга төгөлдөр томоохон хэмжээний оршил, Зүүнгар. Дорнод Туркестан дахь Чин улсын ноёрхол, түүний эсрэг хөдөлгөөн, Зүүнгарт (1871-1876) явуулсан залхаан цээрлүүлэх ажиллагаа, Дорнод Туркестаныг Чин улсын цэрэг эзэлсэн нь (1877-1878) гэх мэт дөрвөн бүлэг, тайлбар сэлт, номзүйн жагсаалтаас бүрдэж байна. Зохиолыг зөвлөлтийн Шинжлэх ухааны Академийн Дорнодахины судлалын хүрээлэнгээс эрхэлж ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн С. Л. Тихвинский редакторлажээ.

Зохиогч тухайн сэдвээр Чин улсаас Зүүнгар, Дорнод Туркестанд явуулсан «залхаан цээрлүүлэх бодлогын» дүр төрхийг гарган харуулах гэсэн гол зорилгоо амжилттай биелүүлж XIX зууны хоёрдугаар хагаст хятад бус ард түмний талаар Чин улсын явуулж байсан их гүрний дээрэнгүй бодлогын талаар бидний мэд-

лэгийг өргөтгөж байна. «Нэг зэрлэгийг нөгөөгөөр нь даруулах» гэдэг хятадын хаадын уламжлалт зарчмыг манжийн хаад, ноёд Зүүнгар, Дорнод Туркестанд өргөн туршихаар барахгүй улам нарийсгаж «нэг зэрлэгийг нөгөөгөөр нь захируулах» бодлого явуулж орон нутгийн феодалуудад үе угсаа залгамжлах манжийн зэрэг хэргэм (ван, гүн бэйль, бэйс), угсаа үл залгамжлах үндэсний үүрэг тушаал (хаким-бек, ишик-ага-бек гэх мэт) хоёрыг хослуулан шагнаж тэднийг өөртөө татаж байсан нь өгүүлэн буй зохиолоос (22-р тал) илт харагдаж байна.

Чин улсын төрд үйлчилсэн эдгээр феодалууд, тэднийг гартаа атгаж буй жанжин, захирагч зэрэг Чин улсын их бага тушаалын түшмэл, тэдгээрийн хүнд суртлын аппаратын хажуугаар манжийн засгийн тугийн цэрэг, хот хамгаалах хятад цэрэг нийлж зөвхөн Тэнгэрийн тэтэгсэн хааны (1736-1796) үед 41 мянга гаруйд хүрч (23-р тал) байжээ. Манж-хятадын цэргийн хөсөг унаа, хүнс, хоол зэрэг хөрөнгө зардлын ихэнхи нь ард түмнээс хураах алба татвараас бүрдэх учир орон нутгийн хун амын амь зуултад хүндээр нөлөөлөхийн зэрэгцээ манжийн худалдаа-санхүүгийн харгис бодлогын уршгаар орон нутгийн үйлдвэр хоцрогдож, уурхай баялаг нь хорогдож байжээ. Түүнчилэн хас эрдэнийн чулуу, түүгээр хийсэн гоёлын зүйл, үнэт үслэг эд зэрэг Дорнод Туркестаны ховор нандин бүтээгдэхүүнд Чин улс онц эрхээ тогтоож (24-р тал) гадаад худалдаа их хятадын шунахай худалдаачдын гарт бүрмөсөн шилжсэн (25-р тал) зэрэг нь мөлжигч, мөлжигдөгсөдийн хоорондох зөрчлийг хурцатгаж, мөлжигдөгч ард олны дургүйцэл туйлдаа хүрч улмаар удаа дараагийн бослого хөдөлгөөнд хүргэжээ.

Чин улсын эрх баригчид хятад бус үндэстнийг хооронд нь дайсагнуулж нэгийг нөгөөгөөр нь даруулдаг сурамгай аргыг уламжлан авч үргэлжлүүлсэн нь Зүүнгарт 1864 онд өрнөсөн үндэсний чөлөөлөх хөдөлгөөнийг дарахад Улиастай жанжинд тушаал өгч баруун Монголоос удаа дараа олон мянган цэрэг дайчлан довтолгож босогчдод хядуулж байснаас (40-р тал) илэрхий байна. Гэвч манжийн цэргийн гол хэс-